



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
**ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ
ГАЗАР**

Нийслэлийн засаг захиргааны IV байр,
4 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, 15160-0066
Утас:(976) 7575 7807, Факс: (976) 7575 7809
Цахим шуудан: contact@ub-procurement.mn
Цахим хаяг: www.ub-procurement.mn

2024.03.04 № 03/290

танай _____-ны № _____-т

Тендер шалгаруулалтын баримт бичигт
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Тус газраас зарласан ЭМЯ/20240102064 дугаартай Эрүүл мэндийн салбарын тоног төхөөрөмж (Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг)-ийн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерт захиалагчаас ирүүлсэн техникийн тодорхойлолт өөрчлөгдсөнтэй холбогдуулан Сангийн сайдын 2023 оны А/248 дугаар тушаалаар батлагдсан журмын 2.7 дахь хэсэгт заасны дагуу тендерийн баримт бичгийн нэмэлт, өөрчлөлтийг хавсралтаар хүргүүлж байна. Үүнд:

1. Монгол улсын Эрүүл мэндийн яамны албан бичиг – 2 хуудастай;
2. Нийслэлийн Эрүүл мэндийн газрын албан бичиг – 1 хуудастай;
3. Техникийн тодорхойлолт - 2 хуудастай;
4. Техникийн тодорхойлолтын харьцуулсан хүснэгт - 3 хуудастай;
5. Бараа нийлүүлэлтийн хуваарь - 1 хуудастай;

Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журмын 4.6 дахь хэсэгт заасны дагуу сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичгийн салшгүй хэсэг болох тодруулга, нэмэлт, өөрчлөлтийг тендер хүлээж авах эцсийн хугацаа хүртэл шалган нягталж, түүнд нийцүүлэн тендер бэлтгэнэ.

Хавсралт 9 хуудастай.